

ХУГАЦААТАЙ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ГЭРЭЭ /Иргэн/

20__ оны __-р сарын __-ны өдөр

Дугаар: _____

_____ хот

Энэхүү хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 454-456 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйл, “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 2 дугаар бүлэг, Төрийн банкны бодлого, журам, хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1 хаягт орших, 9007001011 дугаар улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5341469 регистрийн дугаартай, Төрийн банк ХК, түүнийг төлөөлж _____ салбар/ тооцооны төв /цаашид “Банк” гэх/,

Нөгөө талаас _____ регистрийн дугаартай _____ хаягт орших, эцэг/эхийн нэр _____ өөрийн нэр _____ Хамтран эзэмшигч _____ регистрийн дугаартай _____ хаягт орших, эцэг/эхийн нэр _____ өөрийн нэр _____ (цаашид “Харилцагч” гэх), хамтад нь “Талууд” гэх) нар Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авахаар дор дурдсан нөхцөлийг хүлээн зөвшөөрч, харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр Төрийн банканд хугацаатай хадгаламжийн данс эзэмших, түүнд мөнгөн хөрөнгө тодорхой нөхцөлтэйгөөр байршуулах, үйлчлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Дансны дугаар: _____ Валют: Төгрөг , Ам.доллар , Бусад
- 2.2. Бүтээгдэхүүний нэр: Иргэдийн хугацаатай ; Хүүгээр арвижих ; Малчны ; Бусад _____;
- 2.3. Жилийн хүү: _____%; Хугацаа цуцалсан тохиолдолд тооцох/бууруулсан/ хүү: _____%;
- 2.4. Хуримтлуулсан хүү олгох давтамж: Сарын эцэст ; Сарын ойн дээр ; Хугацааны эцэст ;
- 2.5. Хүү олгох дансны дугаар / Хүүгээр арвижих, Малчны хадгаламж/: _____ (Хүүгээр арвижих хадгаламжийн үндсэн дансанд хүү олгох бол хүүгээс хүү тооцогдох ба жилийн бодит хүү% байна)
- 2.6. Заавал байлгах доод үлдэгдэл: _____ Хадгаламж нээж байгаа мөнгөн дүн: _____
- 2.7. Хадгаламжийн хугацаа: _____/хоног; сар; жил/. Гэрээ эхлэх, дуусах огноо: _____
- 2.8. Данснаас зарлагын гүйлгээ хийхгүй.
- 2.9. Энэхүү хадгаламжийг барьцаалан зээл авсан тохиолдолд зээлийн гэрээ болон барьцааны гэрээнд заасны дагуу энэхүү гэрээний 2.7-д заасан хугацаанаас өмнө хадгаламжаас үл маргах журмаар төлбөрийг гүйцэтгүүлнэ. Энэ тохиолдолд гэрээний 2.8 дахь заалт хамаарахгүй болно.
- 2.10. Хугацаа дуусахад гэрээг мөн хугацаагаар автоматаар сунгах удаа: _____; /Сунгахгүй бол 0 /тэг/ гэж тэмдэглэнэ. /
- 2.11. Гэрээний хугацаа дуусахаас өмнө зарлагын гүйлгээ хийх хүсэлт гаргасан, гэрээний хугацаа дуусах үед сунгах хүсэлтээ бичгээр гаргаагүй, гэрээг сунгах захиалга өгөөгүй болон автоматаар сунгах захиалга биелж хугацаа нь дууссан хугацаатай хадгаламжийн данс хугацаагүй хадгаламжийн данс руу шилжинэ.
- 2.12. Гэрээг автоматаар сунгах үед тус бүтээгдэхүүний тухайн үед мөрдөгдөж байгаа хүүгийн хэмжээ, нөхцөл үйлчилнэ.
- 2.13. Хугацаатай хадгаламжийн гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах хүсэлтийг бичгээр гаргах ба энэхүү гэрээний 2.3-д заасны дагуу хугацаа цуцалсан тохиолдолд тооцох бууруулсан хүүгээр хүүг тооцож, байршсан хугацааны хүүг олгоно.
- 2.14. Энэхүү гэрээний 2.9-т заасан нөхцөлөөр хадгаламжийн гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцалж, төлбөр гүйцэтгүүлэх тохиолдолд 2.3-д заасны дагуу “хугацаа цуцалсан тохиолдолд бууруулсан хүү”-ээр тооцно.
- 2.15. Хадгаламжийн дансны гэрээний сунгалт хийгдсэнээс хойш 7 хоногийн хугацаанд зарлагын гүйлгээ хийхэд гэрээний нөхцөлд өөрчлөлт орохгүй.
- 2.16. Хадгаламж барьцаалсан онлайн зээлийг харилцагч өөрийн цахим банкны эрхээр хандаж авах ба хадгаламж барьцаалсан онлайн зээлийн гэрээ байгуулагдсанд тооцож гэрээг банканд цахим баримт /өгөгдөл/ хэлбэрээр хадгална.
- 2.17. Хадгаламж барьцаалсан онлайн зээлийн нөхцөл нь Банкны тухайн үед мөрдөгдөж буй үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу байна.
- 2.18. Хугацаатай хадгаламж барьцаалсан зээлийг хугацаатай хадгаламжийн хүү олгох жилийн ойн дээр төлүүлж байгаа тохиолдолд хадгаламжийн хугацаа цуцлагдахгүй бөгөөд энэхүү гэрээний 2.7-д заасан гэрээ дуусах өдөр хүртэл хэвээр үргэлжилнэ. Бусад зээлд хугацаатай хадгаламж барьцаалсан тохиолдолд төлбөрийн зөрчил үүссэн тухай бүр барьцаалсан хадгаламжийн хүүг бууруулахгүйгээр зарлагын гүйлгээг хийж, зээл, хүүний төлбөрийг төлүүлнэ.
- 2.19. Хугацаатай хадгаламжийн хамтран эзэмшигч нь харилцан тохиролцож нөгөө хамтран эзэмшигчээс зөвшөөрөл авахгүйгээр гэрээний 2.16-д заасан эрхийг дангаараа хэрэгжүүлэх зөвшөөрлийг энэхүү гэрээгээр олгож байна.
- 2.20. Тус бүтээгдэхүүний нөхцөлд өөрчлөлт орвол харилцагч тухайн өөрчлөгдсөн нөхцөлийг дагаж мөрдөх бөгөөд эс зөвшөөрвөл гэрээгээ цуцалж болно.
- 2.21. Данс эзэмшигч нь энэхүү гэрээний нөхцөл, данс эзэмшигчтэй байгуулсан _____ тоот “Цахим үйлчилгээний ерөнхий гэрээ”-ний нөхцөл болон үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлтэй танилцсан бөгөөд үүний дагуу үйлчлүүлэхийг зөвшөөрч байна.
- 2.22. Харилцагч хадгаламжийн хуримтлагдсан хүүг өөрийн нэр дээрх бусад дансанд хуваан авч болно. Энэ талаар хадгаламжийн хүү кап хийхийн өмнөх аль нэг өдөр банканд хүсэлт гаргасан байна.
- 2.23. Банк гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал /гал түймэр, үер, газар хөдлөлт, ган, зуд зэрэг байгалийн гамигийн шинжтэй үзэгдэл, тахал, байлдааны ажиллагаа, хорго цээр/ үүссэний улмаас Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийн дагуу энэхүү гэрээний 2.3-т заасан хүүг зогсоох, бууруулах, хүүг тооцохгүй байж болно.

ГУРАВ. ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Харилцагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 3.1.1. Банкны ҮХШЕН-тэй танилцсаны үндсэн дээр Гэрээ болон журамд заасны дагуу данс нээлгэх, төлбөр тооцооны үйлчилгээ авах,
- 3.1.2. Дансны гүйлгээ, үлдэгдлийг дансны хуулгатай тулган шалгах,
- 3.1.3. Банканд нэн даруй мэдэгдэж төлбөрийн гүйлгээ гүйцэтгэхээс өмнө төлбөрийн даалгавраа цуцлах,
- 3.1.4. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг тогтоосон журмын дагуу авах,

- 3.1.5. 18 нас хүрч, эрх зүйн бүрэн чадамжтай болсноор Банканд ирж өөрийн гарын үсгийн загварыг өгч уг дансыг зарцуулах эрхээ нээлгэх,
- 3.1.6. Данс хамтран эзэмшигч нь нөгөө данс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тухайн данснаас орлого, зарлагын гүйлгээ хийх, гэрээг цуцлах, дансны тодорхойлолт, хуулга авах, дансан дах үлдэгдэл битүүмж хийх болон Банкны бусад үйлчилгээг авах,
- 3.1.7. Банк гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах.
- 3.2. Харилцагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**
- 3.2.1. Банкаас үйлчилгээ авах бүртгээ хүчин төгөлдөр баримт бичгээр үйлчлүүлэх, өөрийн болон хамтран эзэмшигчийн талаарх үнэн зөв мэдээлэл, баримтыг Банканд гаргаж өгөх, хаяг, утас, ажил, албан тушаал зэрэг мэдээлэл өөрчлөгдөхөд Банкны ажилтанд мэдэгдэж холбогдох өөрчлөлтийг хийлгэх,
- 3.2.2. Төлбөр тооцооны баримтыг үнэн зөв, бүрэн бүрдүүлэх, Банкны ажилтны шаардсан баримт мэдээллийг өгөх,
- 3.2.3. Дансанд заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах, үйлчилгээний хөлсийг төлөх,
- 3.2.4. Дансны дугаар болон холбогдох мэдээллийн нууцлалыг хамгаалах,
- 3.2.5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу хүүний орлогоос татвар төлөх,
- 3.2.6. Дансаа гуравдагч этгээдэд дамжуулан ашиглуулахгүй, бусдын гүйлгээг шилжүүлэхгүй бөгөөд хууль бус үйлдлээс үүдэн гарах хохирлыг хариуцах,
- 3.2.7. Харилцагч хугацаа сунгах хүсэлтээ бичгээр гаргаагүй, хугацаа сунгах захиалга өгөөгүйгээс хугацаатай хадгаламжийн хугацаа дуусаж хугацаагүй хадгаламжид шилжсэнтэй холбоотой аливаа гомдлыг банк хариуцахгүй
- 3.2.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Банкны ажилтны шаардсан аливаа баримт мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгөх, хууль, тогтоомжийг зөрчихгүй байх,
- 3.2.9. Банкны үйл ажиллагааны алдаанаас харилцагчийн дансанд илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд Харилцагч үл маргах журмаар эргүүлэн төлөх,
- 3.2.10. Данснаас 40 000 000.00 /дөчин сая/ төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаас дээш дүнтэй мөнгө бэлнээр зарлагдах бол энэ тухайгаа ажлын 1 хоногийн өмнө Банканд мэдэгдэх.

ДӨРӨВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Банк дараах эрхийг эдлэнэ. Үүнд:**
- 4.1.1. Хууль тогтоомжид заасны дагуу Харилцагчийн хувийн хэргийг бүрдүүлэх, шинэчлэх болон бусад үйлчилгээтэй холбогдуулан нэмэлт баримт, мэдээллийг шаардах, гаргуулан авах,
- 4.1.2. Банкны ҮХШЕН-д заасны дагуу үйлчилгээний шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутгах, дансан дах үлдэгдэл нь шимтгэл, хураамжийг суутгахад хүрэхгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах,
- 4.1.3. Гэрээнд зааснаас бусдаар харилцагчийн дансанд илүү хүү бодогдсон, гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн зэрэг тухайн харилцагчид хамааралгүй тохиолдолд Харилцагчийн данснаас тухайн мөнгөн дүнгээр, үл маргах журмаар эргүүлэн авах, залруулах,
- 4.1.4. Карт, хадгаламжийн дэвтрийг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан тухай Банканд мэдэгдээгүй, түүнчлэн бусдад дамжуулснаас Харилцагчийн дансан дах мөнгөн хөрөнгө хууль бусаар ашиглагдсан тохиолдолд учирсан хохирлыг Банк хариуцахгүй,
- 4.1.5. Татварын хууль тогтоомжийн дагуу харилцагчийн дансанд бодогдсон хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад татварын орлогод ногдуулах албан татварыг суутгаж Татварын байгууллагад шилжүүлэх,
- 4.1.6. Тодорхой гүйлгээг эрсдэлтэй, гэмт хэргийн шинжтэй, хууль бус гэж үзвэл гүйлгээг хийхээс татгалзах,
- 4.1.7. Хууль, журам, энэхүү Гэрээг зөрчсөн тохиолдолд харилцагчийн гүйлгээг түдгэлзүүлэх, Банкны санаачилгаар гэрээг цуцалж учирсан хохирлыг төлүүлэх, эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг арга хэмжээг авах,
- 4.2. Банк дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**
- 4.2.1. Харилцагчийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж, хууль, журам, гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй,
- 4.2.2. Харилцагчийн баримт мэдээлэл дутуу, Банкны ажилтны шаардсан мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд аливаа үйлчилгээ үзүүлэхгүй,
- 4.2.3. Харилцагчийн даалгавраар бэлэн ба бэлэн бус хэлбэрээр гүйлгээг хийх,
- 4.2.4. Өөрийн буруутай үйлдлийн улмаас Харилцагчид учруулсан хохирлыг нотлогдсон хэмжээгээр хариуцан нөхөн төлөх,
- 4.2.5. Үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл, заавар зөвлөмжийг харилцагчид өгөх,
- 4.2.6. Харилцагчийн нэмэлт үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх,
- 4.2.7. Данс идэвхгүй төлөвт шилжсэн ба дансны үлдэгдэл ТЭГ /0/ болсон тохиолдолд дансыг хаах.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- 5.1. Дараах нөхцөлд Гэрээ дуусгавар болно. Үүнд:
- 5.1.1. Харилцагч дансаа хаалгах хүсэлт гаргасан,
- 5.1.2. Харилцагчийн бүрдүүлсэн баримт бичиг хуурамч болох нь тогтоогдсон,
- 5.1.3. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хууль бус үйл ажиллагаанд ашигласан,
- 5.1.4. Хуульд заасан бусад үндэслэлээр.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Талууд Гэрээ болон хууль тогтоомж зөрчсөний улмаас учирсан хохирлыг хариуцна.
- 6.2. Харилцагчийн дансны үлдэгдэл хүрэлцээгүй, төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр дутуу, буруу болон хүлээн авагч банкны үйлчилгээний доголдол зэргээс Харилцагчийн төлбөр саатсан бол үүссэн үр дагаврыг Банк хариуцахгүй.
- 6.3. Баримт бичгээ хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, нууц үгээ бусдад задруулсан, дамжуулсан, ашиглуулсан зэрэг Харилцагчийн буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас өөрт болон бусдад учирсан хохирлыг хариуцна.
- 6.4. Харилцагч төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, залилах, хууран мэхлэх, Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчих замаар Банканд хохирол учруулсан тохиолдолд хохирлыг харилцагчийн данснаас үл маргах журмаар төлүүлнэ.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү Гэрээг монгол хэл дээр үйлдэж гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 7.2. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

7.3 Гэрээ байгуулсан өдрийн байдлаар Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж:

Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	Төгрөг	Валют
Бэлэн мөнгөний орлогын гүйлгээ	Хураамжгүй	Бэлэн валютын шимтгэл
Бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ*		
Улаанбаатар хот, Аймгийн төв	200 төг	200 төг + Бэлэн валютын шимтгэл
Сум, суурин газар 1 сая төгрөгөөс дээш	200+0.01%	
Бэлэн бус шилжүүлэг /банк дотор/	150 төг	200 төг
Бэлэн бус шилжүүлэг /бусад банкуу/	200-500 төг	1,000 төг

* - Хугацаатай хадгаламжийн авто сунгалт хийгдснээс хойш 7 хоногт зарлагын гүйлгээ хийх боломжтой бөгөөд тухайн хугацаанд хийх гүйлгээнд хамаарна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Энэ гэрээний нөхцөлтэй танилцан хадгаламжийн данс нээхийг зөвшөөрсөн:

Данс эзэмшигч 1: Овог нэр, баталгаат гарын үсэг: _____ / _____ Огноо: _____
 Данс эзэмшигч 2: Овог нэр, баталгаат гарын үсэг: _____ / _____ Огноо: _____

Банкны ажилтны нэр, гарын үсэг, тамга тэмдэг: _____ Огноо: _____

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ: Огноо: _____
 Жилийн хүү: _____%; Хугацаа цуцалсан тохиолдолд тооцох хүү: _____%; Дансны доод үлдэгдэл: _____;
 Дансны үлдэгдэл: _____; Хадгаламжийн хугацаа: _____; Гэрээ дуусах огноо: _____
 Данс эзэмшигч 1: Овог нэр, баталгаат гарын үсэг: _____ / _____
 Данс эзэмшигч 2: Овог нэр, баталгаат гарын үсэг: _____ / _____
 Банкны ажилтны нэр, гарын үсэг, тамга тэмдэг: _____ Огноо: _____